

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА,
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ
ТӨЛӨВЛӨХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн дагуу захиалагч төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө, өөрийн хөрөнгө, зээл, тусламж, хандивын хөрөнгө, бусад эх үүсвэрээр тухайн төсвийн жилд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах болон захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтад хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Энэ журмыг хуулийн 4 дүгээр зүйлд заасан бүх захиалагч үйл ажиллагаандаа мөрдөнө.

1.3.Захиалагч хууль болон бусад эрх бүхий этгээдээс баталсан төсвийн дагуу тухайн жилийн төсөвт батлагдсан бараа, ажил, үйлчилгээг төлөвлөх, тайлагнах ажиллагааг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) (цаашид "цахим систем" гэх)-ээр хөтөлнө.

1.4.Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (цаашид "төлөвлөгөө" гэх), худалдан авах ажиллагааны тайлан (цаашид "тайлан" гэх), түүнд оруулсан аливаа өөрчлөлтийг цахим системээр хөтөлнө. Захиалагчийн дээд шатны байгууллага нь төлөвлөгөө, тайлан, тэдгээрт холбогдох өөрчлөлтийг байгууллагын цахим системийн эрхээр хянаж, баталгаажуулна.

1.5.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын худалдан авах ажиллагааны бодлого хариуцсан нэгж (цаашид "нэгж" гэх) нь төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас цахим системээр ирүүлсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, цахим системийн бусад мэдээлэлд үндэслэн захиалагч бүрийн тухайн оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээ хийж, төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг нэгтгэн дүгнэнэ.

Хоёр. Төлөвлөгөө, тайланг хүргүүлэх үе шат

2.1.Захиалагч төрийн байгууллага, албан газар, төрийн болон орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газрын төсвийн шууд захирагч, гүйцэтгэх удирдлага нь төлөвлөгөө, тайланг баталж, дараах үе шатаар холбогдох дээд шатны байгууллагад цахим системээр ирүүлнэ:

2.1.1.Төсвийн шууд захирагч нь төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчийн төлөвлөгөө, тайланг нэгтгэн төсвийн ерөнхийлөн захирагчид;

2.1.2.Төсвийн төвлөрүүлэн захирагчгүй бол төсвийн шууд захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчид;

2.1.3.Төсвийн тухай хуулийн 61.1-д заасны дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний үндсэн дээр санхүүжих байгууллагын төсвийн шууд захирагч нь сум, дүүргийн Засаг даргад, сум, дүүргийн Засаг дарга нь төсвийн шууд захирагчийн төлөвлөгөө, тайланг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн төлөвлөгөө, тайланг нэгтгэн холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагчид;

2.1.4.Журмын 2.1.3-т заасан төсвийн шууд захирагч нь төсвийн төвлөрүүлэн захирагчгүй бол аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга нь төсвийн шууд захирагчийн төлөвлөгөө, тайланг нэгтгэн холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагчид;

2.1.5.Төсвийн ерөнхийлөн захирагч нь дээрх төсвийн захирагчдын төлөвлөгөө, тайланг нэгтгэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуулийн 48.3, 48.4, 49.5-д заасан хугацаанд багтаан ирүүлнэ.

2.2.Захиалагч төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага нь өөрийн байгууллагын төлөвлөгөө, тайланг баталж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөвлөгөө, тайланг нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нэгтгэсэн төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөвлөгөө, тайланг нэгтгэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр ирүүлнэ.

2.3.Захиалагч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага нь өөрийн байгууллагын төлөвлөгөө, тайланг баталж, дараах үе шатаар холбогдох дээд шатны байгууллагад цахим системээр ирүүлнэ:

- 2.3.1. Сум, дүүрэгт харьяалагдах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага нь сум, дүүргийн Засаг даргад, сум, дүүргийн Засаг дарга нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөвлөгөө, тайланг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад;
- 2.3.2. Аймаг, нийслэлд харьяалагдах орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлага аймаг, нийслэлийн Засаг даргад;
- 2.3.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын төлөвлөгөө, тайланг нэгтгэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.
- 2.4. Захиалагч төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн гүйцэтгэх удирдлага нь өөрийн байгууллагын төлөвлөгөө, тайланг баталж төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээдэд, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн төлөвлөгөө, тайланг нэгтгэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр ирүүлнэ.
- 2.5. Захиалагч төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төслийн зохицуулагч нь өөрийн байгууллагын төлөвлөгөө, тайланг баталж төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчид, төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөвлөгөө, тайланг нэгтгэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр ирүүлнэ.
- 2.6. Энэ журмын 2.1-2.5-д заасан захиалагч, түүний төлөвлөгөө, тайланг нэгтгэн хүргүүлэх дээд шатны байгууллага нь цахим системээр холбогдох төлөвлөгөө, тайланг хянан нэгтгэж, хүргүүлснийг баталгаажуулан төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас энэ журмын хавсралтын маягт 4, маягт 5-д заасан баталгаажуулах маягтыг хэвлэн, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад эх хувийг албан бичигт хавсарган хүргүүлнэ.

Гурав. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт

- 3.1. Худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 48 дугаар зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна.
- 3.2. Захиалагч тухайн жилийн төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын маягт 1-ийн дагуу боловсруулж, түүнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, төсөвт өртөг, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга, хэрэгжүүлэх хугацаа болон холбогдох тайлбар, тодруулга зэрэг мэдээллийг тодорхой тусгасан байна.
- 3.3. Тухайн жилийн төсөвт он дамжин хэрэгжихээр тусгагдсан худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд тусгаж, тайлбарт он дамжин хэрэгжиж байгаа талаар дурдана.
- 3.4. Хуулийн 46.1.8-д заасан тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан байна.
- 3.5. Захиалагч өөрийн байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тухайн байгууллагын зорилтыг хангах, үр ашигтай, зөв төлөвлөгдсөн эсэхийг хянан, цахим системээр батална.
- 3.6. Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн харьяа төрийн байгууллага, албан газар, төрийн болон орон нутгийн өмчит улсын төсөвт үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын тухайн онд худалдан авахаар энэ журмын 3.5-д заасны дагуу баталсан төлөвлөгөөг хянан нэгтгэн цахим системээр баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр ирүүлнэ.
- 3.7. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын тухайн онд худалдан авахаар энэ журмын 3.5-д заасны дагуу баталсан төлөвлөгөөг хянан нэгтгэж цахим системээр баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр ирүүлнэ.
- 3.8. Төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд нь өөрийн харьяа төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн тухайн онд худалдан авахаар энэ журмын 3.5-д заасны дагуу баталсан төлөвлөгөөг хянан нэгтгэн цахим системээр баталж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр ирүүлнэ.
- 3.9. Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь энэ журмын 3.6, 3.7, 3.8-д заасан төлөвлөгөөг уг журмын хавсралтаар баталсан маягт 1-ийн дагуу санхүүжилтийн эх үүсвэр баталсан тогтоол, шийдвэрийг хавсарган, дараах хугацаанд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр баталж, илгээнэ.
- 3.9.1. Улсын болон орон нутгийн төсөв батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор;
- 3.9.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө баталснаас хойш ажлын 10 хоногийн дотор;
- 3.9.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө баталснаас хойш ажлын 10 хоногийн дотор;

3.9.4.Төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө баталснаас хойш ажлын 10 хоногийн дотор;

3.9.5.Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийг баталснаас хойш ажлын 10 хоногийн дотор.

3.10.Нэгж нь энэ журмын 3.9-д заасны дагуу ирүүлсэн төлөвлөгөөг зохих журмын дагуу төлөвлөсөн эсэхийг хянаж, хууль, журамд нийцсэн бол цахим системээр баталгаажуулна. Төлөвлөгөө нь хууль журамд нийцээгүй тохиолдолд үндэслэлийг дурдан буцаана.

3.11.Тухайн жилийн төсөвт тодотгол хийсэн, хуульд заасан бусад эх үүсвэр батлагдсан, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаар төсөвт зохицуулалт хийснээс хойш ажлын 10 хоногт багтаан захиалагч төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, холбогдох дээд шатны байгууллагаар батлуулахаар цахим системээр илгээнэ. Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь өөрчлөлтийг хянаж, цахим системээр батална.

3.12.Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 3.13-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногт багтаан төлөвлөгөөнд тусган, цахим системд бүртгэж, холбогдох дээд шатны байгууллагаар батлуулахаар цахим системээр илгээнэ. Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь нэмэлт, өөрчлөлтийг хянаж, цахим системээр батална.

3.13.Батлагдсан төлөвлөгөөнд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

3.13.1.Тухайн жилийн төсөвт тодотгол хийсэн, хуульд заасан бусад эх үүсвэр

батлагдсан, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаар төсөвт зохицуулалт хийсэн;

3.13.2.Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн тухайн онд хэрэгжүүлэхээр батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол, хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад хүндрэл үүссэн.

3.14.Төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлт нь батлагдсан нийт төсөвт өртгөөс нэмэгдсэн бол нэгж уг нэмэлт, өөрчлөлтийн хууль журамд нийцсэн эсэхийг хянан, цахим системээр баталгаажуулна.

3.15.Захиалагчийн боловсруулсан төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар энэ журмын 5 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулж болно.

3.16.Батлагдсан төлөвлөгөөг цахим системд нийтэлснээр хуулийн 48.5-д заасан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлсэнд тооцно.

Дөрөв. Худалдан авах ажиллагааны тайлагналт

4.1.Захиалагч нь тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим системийн холбогдох талбарт энэ журмын хавсралтын маягт 2-ын дагуу боловсруулж, энэ журмын 2 дугаар зүйлд заасан үе шатны дагуу холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор цахим системээр ирүүлнэ.

4.2.Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг энэ журмын хавсралтын маягт 2-ын дагуу цахим системд хянан нэгтгэж, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр ирүүлнэ.

4.3.Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг эрх шилжүүлсэн төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнана.

4.4.Эрх шилжиж ирсэн худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг эрх хүлээн авсан этгээд нь энэ журамд заасан хугацаанд шилжүүлсэн этгээдэд цахим системээр тайлагнана.

4.5.Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, зохих ёсоор хэрэгжүүлээгүй үндэслэл, тайлбарыг тайланд тусгана.

4.6.Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цахим системийн ашиглалт болон захиалагчаас Ерөнхий гэрээгээр худалдан авсан бараа, үйлчилгээний тайланг нэгтгэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад энэ журмын хавсралтын маягт 3-ын дагуу цахим системд тайлагнаж, дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр ирүүлнэ.

4.7.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 4.2-т заасны дагуу ирүүлсэн тайланг нэгтгэн энэ журмын 5.1-д заасан шалгуур үзүүлэлтийн хүрээнд нэгдсэн тайлан боловсруулж, Засгийн газарт тайлагнана.

**Тав. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих,
шинжилгээ, үнэлгээ хийх, нэгтгэн дүгнэх**

5.1. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиалагчаас цахим системд нийтэлсэн төлөвлөгөө, тайлан, цахим системийн холбогдох бусад мэдээлэлд үндэслэн захиалагчийн тухайн жилийн худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дараах шалгуур үзүүлэлтийн хүрээнд хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээ хийнэ:

5.1.1. Батлагдсан төлөвлөгөөг цахим системээр төсвийн асуудал эрхэлсэн

төрийн захиргааны төв байгууллагад цаг хугацаанд нь ирүүлсэн эсэх;

5.1.2. Тайланг цахим системээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цаг хугацаанд нь ирүүлсэн эсэх;

5.1.3. Төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт орсон эсэх;

5.1.4. Төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагаанд холбогдох журам, аргыг баримталсан эсэх;

5.1.5. Төлөвлөгөөнд заасан хугацаанд тендер зарласан эсэх;

5.1.6. Тендерийн урилгыг цахим системд нийтэлсэн эсэх;

5.1.7. Тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулах, татгалзах, шалгараагүй талаар мэдэгдэл хүргүүлсэн эсэх;

5.1.8. Тендер шалгаруулалтын үр дүнг захиалагчийн холбогдох шийдвэр гарсан өдөр цахим системд нийтэлсэн эсэх;

5.1.9. Гэрээ байгуулах эрх олгогдсон тендерт оролцогчийн тендерийг бусад оролцогчид холбогдох журамд заасан хугацаанд ил болгосон эсэх;

5.1.10. Тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулсан эсэх;

5.1.11. Гэрээний мэдээллийг цахим системд нийтэлсэн эсэх;

5.1.12. Гэрээ байгуулах эрх олгосон асуудлаар гарсан гомдол захиалагчийн талд шийдвэрлэгдсэн эсэх.

5.2. Нэгж нь энэ журмын 4.2-т заасны дагуу ирүүлсэн тайланг цахим системээр хүлээн авсны дараа журмын 5.1-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу захиалагч бүрийн тухайн жилийн худалдан авах ажиллагаанд хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээ хийнэ.

5.3. Энэ журмын 5.2-т заасан хяналт, шинжилгээ, үнэлгээний дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт албан бичгээр хүргүүлж, танилцуулна.

5.4. Энэ журмын 5.2-т заасан хяналт, шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж, Засгийн газарт тайлагнана.

5.5. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын худалдан авах ажиллагааны нэгдсэн дүгнэлтийг тайлбарын хамт тусгана.

5.6. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиалагчийн тайланд хяналт тавьж, шинжилгээ, үнэлгээ хийх явцад илэрсэн зөрчил, дутагдлыг Засгийн газарт хүргүүлэх худалдан авах ажиллагааны улсын хэмжээний нэгдсэн тайланд тусгана.